



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/17

Баянхутаг сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2021 оны А/204, А/222 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баянхутаг сумын Засаг даргын тамгын газрын Архивын баримтанд эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийлгэсэн, зөвлөн туслах үйлчилгээг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Энхтуул – Архив, бичиг хэргийн эрхлэгч

Гишүүд: Д.Алтанчимэг – Улаан-Өндөр багийн Засаг дарга

Х.Энхцэцэг- Сангийн нягтлан бодогч

2. Гэрээнд заагдсан чиг үүргийн хүрээнд хийгдсэн ажлыг хүлээн авч, баримт үйлдэж, тэмдэглэл хөтлөхийг Ажлын хэсэгт /Б.Энхтуул/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЗОЛБОО

